

ГАРЧИГ

<i>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа	5
1.3. Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт.....	6
1.4. Баяжуулалтын технологи.....	6
1.5. Хаягдлын сангийн тооцоо	7
1.6. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц	8
1.7. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө	9
<i>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	10
<i>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ</i>	12
3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж	12
3.2 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим	12
<i>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</i>	15
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
4.2. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	19
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
4.7. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал.....	20
4.8. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	21
4.9. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....	22
4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	22

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт	3
Хүснэгт 2. Төслийн техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	3
Хүснэгт 3. Төсөл хэрэгжих талбайн солбилцол	4
Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим	5
Хүснэгт 5. Их өвөлжөө уурхайн календарь төлөвлөлт	5
Хүснэгт 6. Ил уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмж	6
Хүснэгт 7. Баяжуулах цехийн ажиллах горим ба хүчин чадал	7
Хүснэгт 8. Бүтээгдэхүүн гаргалт	7
Хүснэгт 9. Унд ахуйн хэрэглээний ус	9
Хүснэгт 10. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь	12
Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	16
Хүснэгт 12. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
Хүснэгт 14. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	19
Хүснэгт 15. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
Хүснэгт 16. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	21
Хүснэгт 19. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 20. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь	22

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1: Төсөл хэрэгжих талбайн байршил	4
Зураг 2. “Их өвөлжөө” алтны үүсмэл шороон ордын элсийг баяжуулах технологийн схем	6
Зураг 3. Уурхайн талбайд байрлах тунаах нуур	8

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“ИӨОТ” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, ХУД, 2-р хороо, Нэхмэл, 18-21 тоот. Утас: 9909-3823
3	Төслийн нэр	Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших “Их өвөлжөө” алтны үүсмэл шороон ордыг ашиглах
4	Хүчинтэй хууль эрхзүйн баримт бичгүүдийн жагсаалт	1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 9011732105 Улсын регистрийн дугаар: 6296424 Улсад бүртгүүлсэн: 2018.04.10 2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл: Дугаар: MV-000281 Олгосон огноо: 2007.03.16
5	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, нэрлэбэр	Талбайн хэмжээ: 28.5 га
6	Ордын геологийн бодит (B+C) нөөц	Алт: 9.958 /химийн цэврээр/
7	Ордын үйлдвэрлэлийн нөөц	Элс: 81.2 мян.м ³ Алт: 9.86 /химийн цэврээр/
8	Уурхайн жилийн хүчин чадал	Элс: 81.2 мян.м ³ Алт: 9.86 /химийн цэврээр/
9	Ордын ашиглалтын хугацаа	1 жил

Хүснэгт 2. Төслийн техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
А. ТЕХНИК-ТЕХНОЛОГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД			
-	Жилийн хүчин чадал:		
1	Элс	мян.м ³	81.2
2	Алт /шлих/	кг	11.2
3	Алт /цэвр/	кг	9.86
-	Үндсэн тоног төхөөрөмжүүд:		
1	Экскаватор	шир	1
3	Бульдозер	шир	1
4	Утгуурт ачигч	шир	1
5	Дизель станц	шир	1
6	Автосамосвал, 25 тн	шир	3
7	Скрубер	ком	1
Б. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД			
1	Ордын ашиглалтын хугацаа	жил	1
2	Төслийн анхны хөрөнгө оруулалт	сая.төг	372.2
3	Нийт ажиллагсдын тоо	хүн	33
4	Үйлдвэрлэлийн зардал нийт	сая.төг	987.0
5	Олборлолтын өөрийн өртөг	мян.төг/гр	116.81
6	Борлуулалтын орлого нийт	сая.төг	1 515.5
7	Цэвр ашиг	сая.төг	475.6

Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:

“Их өвөлжөө” нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших MV-000281 тоот тусгай зөвшөөрөлтэй бөгөөд талбайн хэмжээ 28.53 гектар болно. Талбай нь Улаанбаатар хотоос 240 км, Дархан-Уул аймгийн Шарын гол сумаас 10 км зайд газарзүйн дараах солбицолд оршино.


Хүснэгт 3.Төсөл хэрэгжих талбайн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	106	30	14.66	49	15	5.45
2	106	30	12.57	49	15	4.95
3	106	30	13.12	49	15	3.91
4	106	29	55.32	49	14	59.21
5	106	29	55.97	49	14	58.04
6	106	29	28.37	49	14	50.72
7	106	29	28.67	49	15	0.72
8	106	29	50.09	49	15	6.34
9	106	29	50.67	49	15	5.42
10	106	30	13.85	49	15	11.28
11	106	30	13.19	49	15	12.39
12	106	30	25.46	49	15	15.66
13	106	30	26.69	49	15	13.77
14	106	30	22.90	49	15	12.78
15	106	30	24.03	49	15	11.02
16	106	30	20.04	49	15	10.04
17	106	30	21.27	49	15	7.95
18	106	30	14.29	49	15	6.11



Төсөл хэрэгжих талбайн байршил

Дархан-Уул аймаг, Шарын гол сум, "Их өвөлжөө" нэртэй талбай



Зураг 1: Төсөл хэрэгжих талбайн байршил

1.2. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа

Уурхайн жилийн хүчин чадал

Уг үүсмэл ордын алт агуулагч элсний тогтоц нь баруун хойноос зүүн урагшаа сунаж тогтсон, 0-3 градусын хэвтээ уналтай бөгөөд ордын нөөцийн тайланд дурьдсанчлан алт агуулсан давхаргын хувьд ямар нэгэн цэвдэгшил болон усны хүндрэл байхгүй юм. Төлөвлөж буй ил уурхайн хүрэн дэх нийт хуулах хөрсний хэмжээ нь 123.42 мян.м³, олборлох элсний хэмжээ нь 81.2 мян.м³ байхаар тооцоо гарсан.

Уурхайгаас гарах хөрсний 15.6 мян.м³-ийг уурхайн гадна гадаад овоолгод байршуулах бол ашиглалтын эхний сарын сүүлээс эхлэн ашиглагдсан орон зайд тээвэртэй дотоод овоолго үүсгэхээр төлөвлөсөн. Ордын нийт элсний нөөц бага тул олборлолтын ажлыг 1 жилд бүрэн багтаах боломжтой гэж үзсэн.

Уурхайн ажиллах горим

Уурхайн бэлтгэл үйл ажиллагаа 5-р сарын 01-ээс уурхайн талбайд эхлэх бөгөөд уурхайн хөрс хуулалтын ажил 5 сарын 03-аас эхэлнэ гэж тооцсон. Харин уурхайн элс олборлолтын ажил 05 сарын 8-аас эхлэх бөгөөд элс угаах ажил 05 сарын 10-аас эхлэхээр тус тус төлөвлөсөн. Тухайн бүс нутагт ажиллаж буй алтны уурхайнууд нь 11 сарын эхэн хүртэл ажилладаг бөгөөд уурхайн ажлыг 10-р сарын 07 хүртэл үргэлжлэхээр тооцсон. Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг ажиллах ба шлюз авах, ээлж солилцох, хоолонд орох хугацааны нийлбэр нь 2 цаг байна.

Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Жилийн ажиллах хуанлийн өдөр	хоног	365
2	Улирлын чанартай сул зогсолт	хоног	181
3	Баяр ёслолын үеийн амралтын өдөр	хоног	6
4	Цаг агаарын саатал	хоног	4
6	Уурхайн ажиллах хоног	хоног	174
7	Тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт засвар	хоног	25
8	Эвдрэл гэмтлээс шалтгаалах төлөвлөгөөт бус засвар	хоног	18
9	Хөрс хуулалтын ажлын хоног	хоног	131
10	Элс олборлолтын ажлын хоног	хоног	131
11	Элс угаах ажлын хоног	хоног	122
12	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	2
13	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
14	Ээлж солилцох, шлюз авах, хооллох хугацаа	цаг	1.5

Хүснэгт 5. Их өвөлжөө уурхайн календарь төлөвлөлт

№	Ажлууд	Ашиглалтын сарууд			нийт
		1	2	3-5	
1	Хөрс хуулалт, мян.м ³	27.3	26.3	69.8	123.4
2	Элс олборлолт, мян.м ³	17.1	17.6	46.6	81.2
	Нийт уулын цул	44.4	43.9	116.4	204.6

1.3. Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт

Хүснэгт 6. Ил уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмж	Марк	Хүчин чадал	Тоо, ш
1	Экскаватор	HYUNDAI R290LC	1.2 м ³	1
2	Автосамосвал	HOWO 336	25 тн	3
3	Бульдозер	Shantui SD32	6.2 м ³	1
4	Утгуурт ачигч	XGMA XG955II	3.0 м ³	1

1.4. Баяжуулалтын технологи

Ил уурхайгаас олборлосон алт агуулсан элсийг автотээврээр тээвэрлэн угаан баяжуулах төхөөрөмжийн дэргэдэх талбайд авч ирэх бөгөөд утгуурт ачигчийн тусламжтайгаар угаан баяжуулах төхөөрөмжийн тэжээлийн бункерт тэжээнэ. Алт агуулсан элсийг цагт 60 м³ хүчин чадал бүхий скруббер, шлюзийн хослол бүхий багц тоног төхөөрөмжөөр угаан баяжуулна.

Төслийн хугацаанд 81.2 мян.м³ алт агуулсан элс угаан баяжуулах бөгөөд чулуулгийн хамгийн том ширхэглэл 50 мм байна. Скрубберийн 20 мм-ийн торыг нэвтэрсэн алт агуулсан элс бүхий булинга өөрийн урсгалаар урсан хөдөлгөөнт шлюзэнд өгөгдөх ба хөдөлгөөнт шлюзийн хаягдал булинга нь хяналтын хөдөлгөөнгүй шлюзэд өгөгдөн баяжигдах ба шлюзийн хаягдал нь өөрийн урсгалаар урсан хаягдана. Шлюзээс гарах булингын хатуу хэсэг нь налуу траншейд тунаж үлдэх ба үлдсэн хатуу хаягдлыг утгуурт ачигчын тусламжтайгаар эфель, гаалийн овоолгод байршуулна.

Шлюзийн шингэн хаягдал булинга нь өөрийн урсгалаар урсан тунаах нуур руу өгөгдөх ба шлам нь тунаах нууранд тунаж, тунасан усыг үйлдвэрлэлд дахин ашиглана. Шлюзээс гарсан баяжмалыг гүйцээн баяжуулж(сэгсрэх ширээ, гар тэвш, соронзон ялгалт) 85.35% металл авалт бүхий 8.45 кг (химийн цэврээр) алт авна.



Зураг 2. “Их өвөлжөө” алтны үүсмэл шороон ордын элсийг баяжуулах технологийн схем

Баяжуулах цехийн ажиллах горим ба хүчин чадал

Угаан баяжуулах цех нь дулааны улиралд хоногийн 1 ээлжтэйгээр үйл ажиллагаагаа явуулах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байхаар тооцсон.

Хүснэгт 7. Баяжуулах цехийн ажиллах горим ба хүчин чадал

№	Үзүүлэлт	Утга
1	Ажиллах улирал	3 улирал
2	Хоногт ажиллах ээлжийн тоо	1
3	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	12
4	Цаг ашиглалтын коэффициент	0.9
5	Хоногт ажиллах бодит цаг	10.8
6	Угаах төхөөрөмжийн хүчин чадал	60
7	Жигд бус өгөлтийн коэффициент	0.92
8	Угаах тоног төхөөрөмжийн цагийн бодит бүтээл, м ³	55.2
9	Хоногийн бодит хүчин чадал, м ³ /хоног	594.95
10	Нийт элсний хэмжээ, мян.м ³	81.202
11	Ажиллах хоног	137

Их өвөлжөө нэртэй алтны үүсмэл шороон ордыг ашиглах 5 сарын хугацаанд 137.93 мг/м³ дундаж агуулгатай 81.2 мян.м³ элс угаан баяжуулах ба анхдагч элсэн дэх алтны хэмжээ 11.2 кг байна. Технологи туршилтын тайлангаас үзэхэд уг ордын металл авалт нь 85.35% байгаа ба төслийн хугацаанд шлихээр 9.56 кг /8.4 хими цэврээр/ алт олборлон худалдахаар тооцоо гарч байна.

Хүснэгт 8. Бүтээгдэхүүн гаргалт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Бүгд дүн
1	Уурхайгаас олборлосон элс	мян.м ³	81.2
2	Элсэн дэх алтны дундаж агуулга	мг.м ³	137.93
3	Элсэн дэх алтны хэмжээ	кг	11.2
4	Алт авалт	%	85.35
5	Гарган авах алтны хэмжээ, шлихээр	кг	9.56
6	Алтны хэмжээ, химийн цэврээр	кг	8.45
7	Алт алдалт	%	14.65
8	Хаягдал дахь алтны хэмжээ, химийн цэврээр	кг	1.46

1.5. Хаягдлын сангийн тооцоо

Хаягдлын сангийн байгууламж нь далан, хаалт, хаягдлын сан, булинга дамжуулах хоолой, насосны станц зэргээс бүрдэнэ. Элс угаан баяжуулах цехийн хаягдлын сан доорх нөхцөл шаардлагыг хангасан байна. Үүнд:

- ✓ Ашиглалтын үед болон хаалтын дараа тогтвортой байдлаа хадгалах
- ✓ Хаягдал усыг эргүүлж ашиглах боломж бүрдсэн байх
- ✓ Үерийн болзошгүй аюулаас хамгаалагдсан байх
- ✓ Хаягдал тээвэрлэх зардал хямд байх

Баяжуулах цехийн хаягдал нь 20 мм-ээс дээш ширхэглэлтэй галь, 20 мм-ээс доош ширхэглэлтэй эфель байна. Эдгээр хаягдлуудыг нийлүүлж олборлолт явуулсан ил уурхайн орон зайг дүүргэх замаар техникийн нөхөн сэргээлтэд ашиглана. Эфелиэс ялгарсан усыг урьдчилан бэлтгэсэн нуурын тусламжтайгаар тунгааж цэвэршүүлээд эргэлтийн усаар ашиглана. Элс угаалгыг гравитацийн аргаар явуулах тул хаягдал нь химийн хортой материал агуулахгүй. Уурхайн бодит ажиллах хоног 174 байгаа ба элс угаан баяжуулах үйлдвэр нь 137 хоног ажиллана гэж тооцсон. Мөн элс угаалтын ажил нь зөвхөн өдрийн цагаар хийгдэхээр тооцсон тул хаягдлын

далангийн цэвэрлэгээний ажлыг 4-5 хоногтоо 1 удаа орой ээлж буусан үед 2-3 цагийн хугацаанд цэвэрлэх боломжтой юм. Цэвэрлэгээний ажил хийгдэх өдрүүдийг урьдаас ажилчдад мэдэгдэж, тунаах нуурын эргэлтийн усыг бүрэн соруулж, цэвэрлэгээний ажилд бэлэн болгосон байна.

Хаягдлын санд хаягдах булинга өөрийн жингээр тунах ба ялгарсан усыг эргэлтийн усан сан руу насосоор шахаж, эргэлтийн усан сангаас угаах төхөөрөмж эсрэг талаас эргэлтийн усны шахуургуудыг байрлуулан угаах төхөөрөмжүүдийг усаар ханган ажиллана.

Булинга хуримтлуулах сангийн урт, өргөний хэмжээ 51х25 м, гүн нь 2.5-3.5 м байна. Баяжуулах үйлдвэрийн хаягдал нь төслийн нийт хугацаанд 81.12 мян.м³ байна.

№	Үзүүлэлт	Нэгж	Хэмжээ
1	Нийт угаан баяжуулах элс	мян.м ³ /жил	81.2
2	Элсэн дэх алтны агуулга	мг.м ³	137.93
3	Хаягдал дахь алтны агуулга	гр/м ³	0.03
4	Хаягдлын гарц	%	99.99
5	Хаягдалд металл алдалт	%	14.65
6	Хаягдал гаргалт	мян.м ³ /жил	81.12
7	Хаягдал дахь алтны хэмжээ	кг/жил	1.608

1.6. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц

1.6.1. Үйлдвэрийн цахилгаан хангамж

Алтны шороон ордын карьер, оффис, хоолны газар, угаан баяжуулах цех, ажилчдын байр зэрэг цахилгаан хэрэглэгчдийн эрчим хүчийг 150 кВт чадалтай дизель генератороор хангана. Цахилгаан хэрэглэгчид 0.23 кВ болон 0.4 кВ-ын цахилгаан эрчим хүчээр тэжээгдэнэ.

1.6.2. Усан хангамжийн эх үүсвэр, хэрэглээ

Орд ашиглахад шаардлагатай ахуйн зориулалттай ундны усыг Шарын гол сумын худгаас хангаж, үйлдвэрлэлийн хэрэгцээний усыг өмнө Хавчуугийн голыг боон ашиглаж байсан нуур, цөөрмөөс хангахаар төлөвлөсөн болно.

Уурхайд хуучин ашиглагдаж байсан 3640.0 м³ хэмжээтэй тунаах нуур байдаг. /Хаягдлын сангийн зургийг тайланд хавсаргав./



Зураг 3. Уурхайн талбайд байрлах тунаах нуур

Уурхайн технологид ашиглах усыг төслийн талбайд байрлах усан сангаас ашиглах бөгөөд нэмэлтээр ашиглах усыг Хавчуугийн голоос ашиглахаар төлөвлөсөн болно.

Хүснэгт 9. Унд ахуйн хэрэглээний ус

№	Үзүүлэлт	Норм	Хэмжээ	Хоног	Хоногийн усны хэрэглээ, м ³	Жилийн усны хэрэглээ, м ³	Норм
1	Унд ахуйн болон хэрэглээний ус	80 л/хоног	33 хүн /нийт ажилчин/	134	2.64	353.76	А/301 дугаар тушаалын 12-р хавсралт
2	Технологийн хэрэгцээ	4.0 м ³ /м ³	81.2 мян.м ³	134	509.01	68208.0	А/301 дугаар тушаалын 2-р хавсралт
3	Зам талбай	2.0 л /м ²	5000 м ²	Нийт 40 удаагийн усалгаа	10.0	400.0	А/301 дугаар тушаалын 13-р хавсралт
4	Ногоон байгууламж	30.0 л	1000 ш	15 удаагийн усалгаа	30.0	450.0	А/301 дугаар тушаалын 11-р хавсралт
Нийт дүн					551.65	69 411.76	

1.6.3. Барилга байгууламж

Харуулын пост, хашаа. Харуул хамгаалалт, шалган нэвтрүүлэх байр нь гаднаас уурхайн бүсэд нэвтэрч байгаа ажиллагсад болон бусад хүмүүсийн бичиг баримтыг шалгах хамгаалах зориулалт бүхий байр байна. Уурхайн ашиглалт явагдах хэсэг буюу эдэлбэр талбайн эргэн тойронд гадны хүн, мал амьтан нэвтрэхээс сэргийлсэн төмөр хашааг татахаар төлөвлөөд байна.

Уурхайн ажиллагсдын байр, хоолны газар. Уурхайн тосгон нь нийт ажилчдын амрах байр, хоол цайны газар болон удирдлагын байр зэргээс бүрдэнэ. Ажилчдын амрах байр, цайны газар, уурхайн захиргаа болон ариун цэврийн байр зэргийг контейнер болон төсөл захиалагчид бэлэн байгаа монгол гэр сууц ашиглан байгуулахаар төлөвлөсөн. Ажилчдын амьдрах байрны зориулалтаар 5 хана бүхий 5 ширхэг гэр сууц, угаалгын байранд зориулан 1 ширхэг контейнер хаус ашиглахаар төлөвлөсөн. Уурхайн захиргаа, удирдлагын байр болон хоол идэх зориулалтаар 40тн-ын 2 контейнер, 4 ширхэг зөөврийн сууц тус тус ашиглана.

- ✓ Уурхайн захиргаа, нууцын өрөө /алт хадгалах/ – 40 тн-ын 1 контейнер
- ✓ Ажилчдын амрах байр - 5 ширхэг гэр сууц
- ✓ Гал тогоо, хоолны заал – 40 тн-ын 1 контейнер
- ✓ Угаалгын газар – 20 тн-ын контейнер

1.7. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

2026 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсанаар 10.7 мян.м³ элс олборлож, угаан баяжуулахаар төлөвлөсөн болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уул зүй

Монгол орны уул зүйн мужлалаар ордын талбай нь Хэнтийн нурууны баруун хойд хэсгийн дунд зэргийн уулархаг мужид хамаарагдах бөгөөд далайн түвшнээс дээш дунджаар 800 м өндөрт өргөгдсөн, газрын гадаргуугийн хэв шинжээр уулархаг хэв шинжэд хамаарагдана. Хамгийн өндөр цэг нь 969.9 м, нам хэсэг нь талбайн зүүн хойд хэсэгт орших Шарын голын хөндий 718.8 м байдаг байна.

Усан сүлжээ

Хамгийн том гол нь Шарын гол бөгөөд уг голд зүүн талаас Гахайтын гол, хойд талаас нь Хавчуугийн гол, Булгийн хөндийн гол, Шивэртийн гол, Шаазгайтын зэрэг жижиг голууд цутгадаг байна. Шарын гол нь Орхон голын баруун цутгал болон цутгадаг. Хавчуугийн гол нь 14 км урттай. Хавчуугийн голын голдиролын өргөн нь 1-2 м-т хэлбэлзэнэ. Урсгалын хурд 0.4-0.6 м/сек. Хажуу талын жижиг гол горхиуд нь ихэвчлэн бороо болон цасны усаар тэжээгддэг байна.

Уур амьсгал

Ордын талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд хамаарах бөгөөд жилийн дундаж температур нь харилцан адилгүй -4°C -аас -7°C . Хамгийн хүйтэн нь 1-р сар -17°C -аас -36°C байдаг бол хамгийн дулаан сар нь 6,7 бөгөөд дундаж температур нь $+15.3^{\circ}\text{C}$ - $+29.3^{\circ}\text{C}$ байдаг байна. Талбай орчимд жилд дунджаар 300-400 мм хур тунадас унах ба түүний 70-85% нь зуны улиралд бороо хэлбэрээр 15-30% нь өвөл хаврын улиралд унадаг байна. Өвөлдөө 11-р сараас 4-р сар хүртэл цас нилээд их унах ба цасан бүрхүүлийн зузаан нь 15-30 см хүрдэг байна. Энэ дүүрэгт арал маягийн хэлбэртэй олон жилийн цэвдэг илрэх бөгөөд өвлийн улиралд хөрсний хөлдөлтийн зузаан нь 2 м-ээс хэтэрдэггүй байна.

Дэд бүтэц

Ордын талбайд хамгийн ойр орших суурин газар нь Дархан-уул аймгийн Шарын гол сумын төв бөгөөд ордоос баруун урагш авто замаар 40.0 км-т оршино. Харин Дархан-уул аймгийн төв Дархан хот нь ордоос баруун хойш 60 км зайд Хараа голын хөвөөнд байрлана. Дэд бүтцийн хувьд ордын талбайгаас орон нутгийн аймаг, сум болон хүн ам төвлөрсөн хэсэгтэй авто тээврээр харилцах бололцоотой. Хүн амын дунд зэргийн суурьшилтай мужид хамаарах бөгөөд аймаг, сумын хөгжил сайтай. Хүн амын ихэнхи нь газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг, олон ястан үндэстний нутаг юм. Шарын гол – Дарханыг холбосон төмөр замын тээвэртэй, авто замын хувьд засмал хар замтай. Эдгээр нь Улаанбаатар болон бусад аймаг хотуудтай холбогдсон байдаг. Дархан -Уул аймаг нь дэд бүтэц сайн хөгжсөн, дулаан цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй бөгөөд өндөр хурдны шилэн кабель, интернет, утсан болон үүрэн телефоны үйлчилгээ бүрэн нэвтэрсэн газар юм. Ерөнхий боловсролын болон, их дээд сургуулиуд, урлаг соёлын томоохон төв, эмнэлэг, сүлжээ дэлгүүр, төмрийн болон цементийн үйлдвэрүүд, төмөр зам болон засмал хар зам, тохилог гудамж талбай, хүүхдийн парк, хөшөө

дурсгал болон олон тооны зочид буудлуудтай. Хүн ам нь орон сууц болон гэр хороололд оршин суух ба хотын хөгжлийн дагуу худалдаа наймаа, хувийн бизнес эрхэлдэг байна.

Ургамал зүй, Ан амьтан

Их өвөлжөө ордын байрлах хөндий орчмын сав газар нь ой хөвчийн шинж чанартай бөгөөд уулын орой хяр, хажуу, голын хөндийд шилмүүст мод нарс, улиас, хус янз бүрийн бутлаг ургамал ургадаг байна. Голын хөндий нь өвс ургамлаар битүү хучигдсан байдаг ба ан амьтдаас буга хандгай, бор гөрөөс, зэрлэг гахай, чоно, булга байдаг бол жигүүртнээс хур, сойр, хөтүү, голдоо зэвэг, алгана зэрэг загас байдаг байна. Орд орчмын талбайд хүн ам маш сийрэг суурьших ба ялангуяа Их өвөлжөө ордын хөндийд жилийн дөрвөн улиралд хүн суурьшдаггүй байна. Харин Хүйтэний голын дунд адаг хэсэг, Шарын голд хүн ам нилээд нягт суурьшдаг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж

“ИӨОТ” ХХК-ийн “Их өвөлжөө” нэртэй алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанд хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц, магадлан жагсаах, загварчлал, харьцуулсан судалгааны арга зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

3.2 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 10. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Ургамлын бүтцийн өөрчлөлт	X				X		X			X
Хөрсний элэгдэл, эвдрэл	X				X		X	X		
Геологийн тогтоцын өөрчлөлт	X				X		X	X		
Зэрлэг амьтдын орон зай		X		X			X			X
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										X
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	X				X		X		X	
Бэлчээрийн байдал	X				X		X		X	
Эрдэс түүхий эдийн нөөц	X				X		X	X		
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	X									
Урсгал усны хэрэгцээ	X									
Агаарын бохирдол				X					X	
Хөрсний эвдрэл, бохирдол					X		X		X	
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		X								X
4. Байгалийн өнгө төрх, түүхи соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										

Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	X				X		X		X	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	X				X		X		X	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	X			X					X	
Орон нутгийн орлого нэмэгдэх	X			X			X	X		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	X			X					X	
Ажлын байр нэмэгдэх	X									X
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	X			X					X	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		X		X						X
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	X				X		X		X	
Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, ба грунтын усыг бохирдуулах	X						X			X
Ахуйн хаягдал, хогийн ариугал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	X			X		X				X
Хүчтэй салхи, уруйн үер	X			X			X	X		
Дүн	19	3	0	9	10	1	14	5	10	8

Болзошгүй шууд нөлөөлөл:

Хөрс хуулах, элс олборлох, зам гаргах үед хөрсний эвдрэл үүсэх, түүнд өртсөн ургамлан нөмрөг, биологийн төрөл зүйл устгах, суларсан хөрс шорооноос агаарын бохирдол үүсэх

- ✓ Байгалийн хүчин зүйлсээс шалтгаалан хүчтэй салхи, газар хөдлөл, үер зэрэг байгалийн гамшиг бий болох
- ✓ Усны нөөц тодорхой хэмжээгээр хомсдох
- ✓ Ажиллагсдын хайнга ажиллагаанаас гал түймэр гарах
- ✓ Хатуу, шингэн хаягдлыг тогтоосон хугацаанд зайлуулаагүйгээс орчин бохирдох
- ✓ Шатах, тослох материал асгарснаас орчин бохирдох
- ✓ Шатах, тослох материалын ууршилтаас агаарын бохирдол үүсэх
- ✓ Уурхайн машин техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх

Болзошгүй шууд бус нөлөөлөл

- ✓ Элс олборлолтоос бичил биетэн, биологийн төрөл зүйлд нөлөөлөх
- ✓ Хөрс хуулалт болон олборлолтоос шалтгаалан хөрсний үржил шим алдагдах

Урт хугацааны нөлөөлөл

- ✓ Элс олборлолтоос үүдэн гарах урт хугацааны нөлөөлөл нь хөрсний эвдрэл, ургамлан нөмрөг устах зэрэг асуудал болно. Иймд нөхөн сэргээлтийн ажлыг чанартай хийх шаардлагатай.

Богино хугацааны нөлөөлөл:

Орчны дуу чимээ ихсэх, агаарын бохирдол түр хугацаагаар үүсэх, ус хэрэглээнээс цэвэр усны нөөц богино хугацаанд өөрчлөгдөх зэрэг нөлөөлөл үүнд хамаарна.

Эрчимтэй нөлөөлөл:

Нарийвчилсан үнэлгээний үр дүнгээс үзэхэд алт олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд эрчимтэй сөрөг нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагаа нь алтны орд газрын хөрсний эвдрэл, агаарын бохирдол юм.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.

Алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон арилгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөх, түүнд зарцуулагдах зардлыг бодитой тооцоолох, байгаль орчны мониторинг хийхэд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд (БОМТ) тусгагдсан арга хэмжээг төсөл хэрэгжүүлэгч шат дараалалтайгаар хэрэгжүүлэх үүрэгтэй. Хамрах хүрээ БОМТ нь төслийн үйл ажиллагааны цар хүрээнд байгаль орчин, нийгэм хамгааллын дараах асуудлыг хамарч, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

- ✓ Төслийн хүрээнд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж холбогдох зардлыг тусгах,
- ✓ Төслийн хаалт нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж холбогдох зардлыг тусгах
- ✓ Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, зардлыг тусгах
- ✓ Осол, эрсдэл, аюултай нөхцөл байдлын үед хүрээлэн буй орчныг хамгаалах бодлогыг тодорхойлох
- ✓ Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг зааж, холбогдох зардлыг тооцох;
- ✓ БОМТ түүний хэрэгжилтэнд оролцогч талуудыг тодорхойлж, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин									
1	Уурхай орчимд тоосжилт үүсэх	Уурхайн ам орчимд болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Уурхайн гол болон тээврийн зам	км	200.0	0.8	160.0 x 25 удаа = 4 000.0	Зуны хуурай улиралд 7 хоногт 2 удаа	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт MNS 5916:2008
2		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу	ш	1 000.0	2	2 000.0 /ОХШХ/	Жилд 2 удаа	
Гадаргын ба газрын доорхи усны нөөц									
1	Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх	Ус ашиглах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах	Уурхай	Үйл ажиллагааны зардлаас				Жил бүрийн эхэнд	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998.
2		Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх		Үйл ажиллагааны зардлаас				Үйл ажиллагааны турш	
3		Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Гүний худаг	ш	250.0	4	1 000.0 /ОХШХ/	Улиралд 1 удаа	
Хөрсөн бүрхэвч									
1	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах, Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах	Овоолго Шимт хөрсний овоолго	Үйл ажиллагааны зардлаас				Ашиглалтын явцад	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. MNS 5916:2008 “Газар шорооны

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу						ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”
Газрын хэвлий									
1	Элс олборлосоноор газрын хэвлийд хоосон орон зай шинээр үүсгэнэ.	Уурхайн малталтууд болон олборлосон орон зайд бэхэлгээ, хамгаалалтын цул зэргийг үлдээж нуралт үүсэхээс сэргийлнэ	Ил уурхай		Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар			Ашиглалтын явцад	MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
Ургамлан нөмрөг									
1	Уурхайгаас олборлосон элсийг угаан баяжуулах, хөрсний овоолго үүсгэх зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрс, овоолгын талбай					Ашиглалтын явцад	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт. Хадгалалт MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3		Уурхайн тосгон орчимд ногоон байгууламж бий болгох	Уурхайн тосгон	ш	10.0	500.0	5 000.0	10-р сард	
Амьтны аймаг									
1	Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах	Үйл ажиллагааны турш		Ашиглалтын зардлаас			2026 онд	Амьтны тухай хууль: 6.1.3.амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нуггийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах; 6.1.7.үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх;
2026 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын урьдчилсан дүн						9 000.0			

4.2. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 12. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийх	га	2.3	Ашиглалтын зардлаар		2026 онд	MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
2	Биологийн нөхөн сэргээлт	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн тосгон орчимд мод тарих	ш	500	10.0	5 000.0	2026 онд	
3	Татан буулгах, хаалтад бэлтгэх	-	-	-	-	-	-	-
Нийт						5 000.0		

4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	“Ногоон Дархан” хөтөлбөрт оролцох	Дархан-Уул аймгийн БОАЖГ-тай хамтран сонгосон талбайд	1	5 000.0	5 000.0	2026 онд	
Нийт						5 000.0		

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 14. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2026 онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.							

4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 15. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал		Уурхай орчимд археологийн дурсгал илрээгүй болно.					
2	Палеонтологийн дурсгал		Уурхай орчимд палеонтологийн дурсгал илрээгүй болно.					

4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 16. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гал түймэр	Галын булан байрлуулах	Уурхай	1	1000.0		2026 онд	
Нийт					1 000.0			

4.7. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлыг түр хадгалах цэгийг тохижуулах	Уурхай	ш	1 500.0	1	1 500.0	4-р сар	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдлын гэрээ байгуулж, тогтмол тээвэрлүүлэх	Уурхай	сар	100.0	5	500.0	Жилийн турш	
Нийт						2 000.0			

4.8. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанарын болон дуу шуугианы хэмжилт хийх, хөрсний болон усны шинжилгээ хийлгэх ажлыг төлөвлөсөн бөгөөд уг ажлыг гүйцэтгэх явцдаа нөлөөллийн бүсийн иргэд, орон нутгийн төлөөллийг байлцуулах шаардлагатай.

Хүснэгт 18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар				
SO ₂ , NO ₂ , CO, Тоос,	Уурхайн амууд, гол зам, тосгон орчим 3 цэгт	Жилд 2 удаа, хавар, намар	1 000.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаар бохирдуулагч бодисуудын ялгарлын хэмжээ	Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд	Жилд 1 удаа	1 000.0	MNS 5013:2003 Бензин хөдөлгүүртэй автомашин, утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2003 Дизель хөдөлгүүртэй
Дуу шуугиан				
Дуу шуугиан, чичиргээ	Уурхайн талбай, тоног төхөөрөмж, ажлын байранд 3 цэгт	Жилд 2 удаа, хавар, намар	500.0	MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
	Авто тээврийн зам дагуу	Жилд 2 удаа, хавар, намар		MNS 5002:2000 Шуугианы норм, аюулгүй ажиллагаа MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний нефть бүтээгдэхүүний бохирдол	Уурхайн гол зам, тосгон орчим 2 цэгт	Жилд 1 удаа	500.0	MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. MNS 3297:1991 Хот суурин газрын хөрсний ариун Ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм хэмжээ
Усан орчин				
Унд ахуйн зориулалтаар ашиглах усны pH, TDS, нийт хатуулаг, исэлдэх чанар, Ca, Mg, Na, K, NH ₄ , нийт Fe, HCO ₃ , Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , амт, үнэр, өнгө, тунгалаг чанар, эрдэсжилт г.м	Уурхайн унд ахуйн хэрэглээний усыг авдаг худагас	Жилд 1 удаа	1 000.0	MNS ISO 5667-1 : 2002 Усны чанар. Дээж авах 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар MNS ISO 5667-3 : 2019 Усны чанар. Дээж авах. 3-р хэсэг: Усны сорьцтой харьцах ба сорьцыг тогтворжуулах
Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн зардлын урьдчилсан дүн			4 000.0	

4.9. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 19. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			4-5-р сар	6-8-р сар	9-10-р сар		
1	Уурхайн бэлтгэл ажлыг бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар				Уурхайн дарга	
2	УАТөлөвлөгөө болон БОМТ-г боловсруулан батлуулах	-				Ашиглалтын инженер, БО-ны мэргэжилтэн	
3	БОМТ-нд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх	БОМТ-ний зардлаар				Байгаль орчны мэргэжилтэн	
4	Ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах	3 000.0				Уурхайн дарга	

4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлдөд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 20. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа	Зардал
1	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдлыг танилцуулах	Хэнтий аймгийн БОАЖГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	V сард	1 000.0 мян.төг
2	Уурхайн үйл ажиллагааны тухай тайлан мэдээг орон нутгийн албан ёсны цахим хаягаар танилцуулах, иргэдийг мэдээллээр хангах	Төслийн нөлөөллийн бүсийн иргэд, сумын иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	X сард	
3	Нийт хийгдсэн ажлын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлагнал	Дархан-Уул аймгийн БОАЖГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	X сард	

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 30.0 сая төгрөгийг төлөвлөж өглөө. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд 9.0 сая төгрөг, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд 5.0 сая.төг, хог хаягдлын менежментийн арга хэмжээний зардалд 2.0 сая.төг, ОХШХ-т 4.0 сая төг, осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд 1.0 сая.төг, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд 3.0 сая.төг, төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах ажилд 1.0 сая.төг зарцуулахаар тооцсон болно.